



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 16 өдөр

Дугаар A/33

Өмнөдэлгэр сум

**Ахмадын сан байгуулах, журам батлах
тухай**

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дах хэсэг, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 243 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Байгууллагын төсвийн 1,000,000 (нэг сая) төгрөгөөс доошгүй мөнгөн хөрөнгөөр ахмадын сан байгуулсугай.
- 2.Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг хавсралтаар баталсугай.
- 3.Ахмадын сангийн хөрөнгийг ахмадын сан байгуулан ажиллуулах журмын дагуу зарцуулахыг нягтлан бодогч (М.Алтантуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА



Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ерөнхий боловсролын
сургуулийн 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн
А/33 дугаар тушаалын хавсралт

АХМАДЫН САН БАЙГУУЛАН АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Ахмад настны тухай хуулийн 14.7-д заасан Ахмадын сан (цаашид "сан" гэнэ)-г байгуулан ажиллуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Байгууллага нь өөрийн төсвийн 1,000,000 төгрөгийн мөнгөн хөрөнгөөр ахмадын сан байгуулна.
- 1.3. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг байгууллагын удирдлага хариуцан гүйцэтгэнэ.

Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт

- 2.1. Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:
 - 2.1.1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны орлого болон батлагдсан төсвөөс санд төвлөрүүлсэн хөрөнгө;
 - 2.1.2. Сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй чөлөөт үлдэгдэл хөрөнгө;
 - 2.1.3. Бусад эх үүсвэр.

Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

- 3.1. Сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хуулийн 12.1, 14.6-д заасан дараах арга хэмжээнд зарцуулна:
 - 3.1.1. Цагаан сар, ахмадын өдрийг тохиолдуулан хүндэтгэл үзүүлнэ.
- 3.2. Сангийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд ашиглах, зарцуулахыг хориглоно.
- 3.3. Ахмадын хороо, зөвлөлийн албан ёсны саналыг үндэслэн байгууллагын удирдлага хүсэлтийг шийдвэрлэнэ.
- 3.4. Байгууллага өөрчлөн зохион байгуулагдсан, хувьчлагдсан тохиолдолд сангийн хөрөнгийг ахмадуудын бүртгэлийн хамт тухайн байгууллагын эрх, үүргийг шилжүүлэн авсан хуулийн этгээдэд шилжүүлнэ.
- 3.5. Байгууллага татан буугдсан тохиолдолд сангийн үйл ажиллагааг зогсоож, цаашид харьяалах байгууллагагүй болсон тухай ахмадуудад мэдэгдэн, тэдгээрийн бүртгэлийг харьяа сум, дүүргийн Засаг даргад шилжүүлнэ.

Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, тайлан

- 4.1. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад мэргэжлийн хяналт, аудит, санхүүгийн байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавина.
- 4.2. Ахмад настанд дэмжлэг олгох, сангийн гүйцэтгэлийг тайлагнах асуудлыг тухайн байгууллагын санхүү хариуцан гүйцэтгэнэ.
- 4.3. Байгууллагын захиргаа нь сангийн орлого, зарлагын жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаргаж холбогдох байгууллагад шалгуулна.
- 4.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ахмадын байгууллага энэхүү журмын хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавина.